БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
САЙД НАРЫН ЗӨВЛӨЛИЙН
1946 ОНЫ 1-Р САРЫН 11-НИЙ ӨДРИЙН
3 ДУГААР ХУРЛЫН ТОГТООЛ

Гадаад явдлын яамны зохион бай-
гуулалтын тухай

Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.1941 оны 9-р сарын 19-ний өдөр батлагдсан БНМАУ-ын Гадаад явдлын яамны дүрмийн 4 дүгээр зүйлийг дор дурьдсанаар найруулан өөрчилсүгэй.

Дөрөв.Гадаад явдлын яамны зохион байгуулалт
Гадаад явдлын яам дор дурьдсан хэлтэс,ангиудаар бүрдэх.Үүнд:

1.Европын хэлтэс
2.Дорнод хэлтэс
3.Тогтоол анги
4.Шинэ хүчний анги
5.Аж ахуйн анги бүхий хэрэг эрхлэх газар
6.Гадаад улсад суугаа элчин төлөөлөгчийн ба консулын газрууд.

2.Гадаад явдлын яамны аппаратын зохион байгуулалтын маягийг баталсугай.

ГАРЫН ҮСЭГ.